

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45.20-д заасан “РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ НЭВТРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ”-ын төсөлд ирсэн саналыг тусгасан байдал

№	Санал ирүүлсэн байгууллагын нэр	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан байдал
1	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	Сонгуулийн сурталчилгаа нийтэд мэдээлсэн тайлангийн маягыг тус журмаар батлах	Саналыг авсан. “Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн талаарх нийтэд мэдээлсэн тайлангийн маягт”-ыг тогтоолын хавсралтаар батлуулахаар бэлтгэсэн.
2		5.7 Олон нийтийн радио, телевиз болон бусад радио, телевиз нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн нэвтрүүлсэн талаарх тайланг өөрийн цахим хуудсаар, нийтэд мэдээлсэн тайланг батлагдсан тайлангийн маягтын дагуу өрсөлдөөний асуудал төрийн захиргааны байгууллагад нийтэд мэдээлснээс хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ гэж тодорхой болгох	Саналыг авч журамд тусгасан.
3	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз	2.13 Олон нийтийн радио, телевизийн нэг хоногт хуваарилсан сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн нийт цаг нь тухайн хоногийн нийт эфирийн цагийн 25 хувиас хэтрэхгүй байна гэж хэвээр үлдээх	Саналыг авсан.
4		2.14 Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх санал, хуваарь, цаг боловсруулахад баримталсан зарчмын хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд сонгуулийн төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийг батлах өдрөөс 2 оос доошгүй хоногийн өмнө ирүүлэх гэж өөрчлөх	Саналыг авч журамд тусгасан.
5		Олон нийтийн радио, телевиз нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхдээ Сонгуулийн Ерөнхий Хороонд албан ёсоор бүртгүүлсэн улс төрийн нам, эвсэлд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар ижил тэнцүү хугацааг олгоно. Бие даан нэр дэвшигчдийн тухайд Сонгуулийн Ерөнхий Хороонд бүртгүүлсэн дарааллыг баримтлан, МҮОНРТ-д сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай хүсэлт гаргасан тохиолдолд ижил нөхцөл, тэнцүү хугацаагаар сонгуулийн сурталчилгааны цагийг нэг удаа олгоно.	Саналыг тусгаагүй. АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 45.3-тай зөрчилдөж байгаа тул саналыг аваагүй.